



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 12 дугаар сарын 15 өдөр

Дугаар 94

Хэрлэн сум

LXLIV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 94 дүгээр хуралдаан 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 08:30 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд цомхотгосон хэлбэрээр 75,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Дархлаажуулалтын явцын мэдээлэл, явуулын уушгины эмгэг илрүүлэх үзлэг зохион байгуулах тухай танилцуулах,

Эрүүл мэндийн газар

2. Газрын тосны XIX талбайд Шуурхай бүлэг томилж ажиллуулах талаар хэлэлцэх,

*Эрүүл мэндийн газар,
Тархвар судлаач Г.Ганцэцэг*

3. Хэрлэн сумын хяналтын цэгүүдийн шатахууны болон бусад зардлын асуудлын талаар хэлэлцэх,

Онцгой комиссын гишүүд

4. Малын гоц халдварт өвчний нөхцөл байдлын талаар мэдээлэл танилцуулах,

Мал эмнэлгийн газар

5. Улсын Онцгой комиссын даргын тушаалаар томилогдсон Шуурхай бүлэг Дорнод аймагт мал, амьтны гоц халдварт шүлхий, үхрийн арьс товруутах өвчний тохиолдол бүртгэгдсэн зарим сумдад ажилласан тухай мэдээлэл танилцуулах,

Улсын Онцгой комиссын Шуурхай бүлэг

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн,
ажлын хэсгийн дарга Ш.Ёл.

 / М.Бадамсүрэн
/ х/ч Б.Цогтбаяр

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир нарт:

1.1.Аймгийн Засаг даргын орлогч Ш.Ёлоор ахлуулсан Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэгт Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагчийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулан томилгоожуулж ажиллуулах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,

1.2.Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг дархлаажуулалтын нэмэлт 3 дугаар тунгийн хамрагдалтыг 75-аас дээш хувьд хүргэх, ажлыг эрчимжүүлэх,

Хоёр.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

2.1.Коронавируст халдвар /COVID-19/-ын батлагдсан тохиолдол эрчимтэй нэмэгдэж байгаа тул Матад сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт "Тосон-Уул" XIX талбайд 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түр хугацаагаар хязгаарлалтын дэглэм тогтоох тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
хурандаа Б.Бямба,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа,

Зүүн бүсийн Гадаадын иргэн харъяатын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн Д.Төрхүү,


Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал,
Онцгой комиссын гишүүн Д.Должин нарт:

2.2.Коронавируст халдвар /COVID-19/-ын батлагдсан тохиолдол эрчимтэй нэмэгдэж байгаа Матад сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт "Тосон-Уул" XIX талбайд мэргэжлийн байгууллагуудын албан хаагч нарын бүрэлдэхүүнтэй шуурхай бүлгийг томилж ажиллуулах,

Гурав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

3.1.Мал, амьтны гоц халдварт шүлхий, үхрийн арьс товруутах өвчний тохиолдол ихэнх сумдад бүртгэгдсэнтэй холбогдуулан хяналт тавих зорилгоор


/ М.Бадамсүрэн
/х/ч Б.Цогтбаяр

ажиллаж буй Хэрлэн сумын суурин 3, хөдөлгөөнт 6 хяналтын цэгийн үйл ажиллагааг 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийг дуустал сунгаж ажиллуулах,

АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

3.2.Мал, амьтны гоц халдварт шүлхий, үхрийн арьс товруутах өвчний тохиолдол ихэнх сумдад бүртгэгдсэнтэй холбогдуулан хяналт тавих зорилгоор ажиллаж буй Хэрлэн сумын хяналтын цэгүүд ажилласан шатахуун болон бусад зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа-д:

3.3.Дорнод аймагт мал, амьтны гоц халдварт шүлхий, үхрийн арьс товруутах өвчний тохиолдол бүртгэгдсэн зарим сумдад аймгийн Онцгой комиссын хуралдааны шийдвэрээр ажилласан ажлын хэсгийн шатахууны зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

Дөрөв.Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Аюушмаа-д:

4.1.Аймгийн Засаг даргын нэрэмжит Мал эмнэлгийн салбарын сургалтыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулж ажиллах,

4.2.Малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах,

4.3.Нэгдсэн албаны байрны дэмжлэг үзүүлэх, "Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа" 5368 стандартыг хэрэгжүүлж ажиллах,

4.4.Гоц халдварт өвчний голомтод томилогдон ажилласан албан хаагч, иргэнд томилолтыг 3 дахин нэмэгдүүлэн олгох, томилолт, шатахууны зардлыг тухай бүр шат шатны байгууллагуудад танилцуулж шийдвэрлүүлэх,

4.5.Халдвараас сэргийлэх хувцас хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн нөөц хангалтыг нэмэгдүүлэх,

4.6.Мал эмнэлгийн нэгжүүд болон малчид малдаа тогтмол урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах,

4.7.Сумдын мал эмнэлгийн байгууллагуудад мэргэжлийн чиглэлээр уралдаан зарлаж шат дараатай хэрэгжүүлж ажиллах,


4.8.Мал, амьтны гоц халдварт өвчний үед сумын Онцгой комиссоос ажил зохион байгуулах, хяналт тавих багийг томилж ажиллуулах талаар чиглэл өгч ажиллах,

4.9.Мал, амьтны гоц халдварт өвчнөөр өвчилсөн малд задлан хийсэн дотор эрхтний зураг, бичлэгийг өнгөтөөр хэвлэж иргэд, малчдад сэрэмжлүүлэг хүргэх,

4.10.Цагаан зээрийн нүүдэл хөдөлгөөн ихтэй байдаг бүс нутгаас эхэлж шүлхий өвчний урьдчилан сэргийлэх вакциныг тарих ажлыг зохион байгуулах,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн,
ажлын хэсгийн дарга Ш.Ёл-д:

4.11.Малын эмч нарын нийгмийн асуудлыг дэмжих талаар анхаарч ажиллах,

 / М.Бадамсүрэн
/ Ч.Б.Цогтбаяр

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын
орлогч дарга Ч.Ганбат-д:

4.12.Малын тоо толгойн татварын орлогын 30-аас доошгүй хувийг мал сүргийг эрүүлжүүлэх ажилд зарцуулах талаар сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт албан бичгээр чиглэл хүргүүлэх,

Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Аюушмаа,
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ж.Алимаа нарт:

4.13.Малчдын зөвлөгөөнийг жил бүрт зохион байгуулж ажиллах,

4.14.Малчдад зориулсан цахим гэрчилгээний талаар судалж танилцуулах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,
Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Аюушмаа нарт:

4.15.Малчдад явуулын нийгмийн цогц үйлчилгээг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтүяа-д:

4.16.Мал эмнэлгийн байгууллагад ажиллах хүний нөөц /Мал эмнэлгийн улсын байцаагч, Тархвар зүйч/-ийг хангах, сул орон тоог томилгоожуулах талаар сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт албан шаардлага хүргүүлэх

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ,
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн А.Гантулга нарт:


4.17.Цагаан зээр, чоно хамгаалах аян зарлаж ажил зохион байгуулах,

Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн, хурандаа Б.Бямбаа-д:

4.18.Мал, амьтны гоц халдварт өвчний шалтгаан нөхцөл, эх уурхайг тогтоох, дэгдэлтийн талаар тандалт судалгааг гаргах,

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн А.Гантулга-д:

4.19.Холимог металл тээвэрлэлтийн маршрут, халдваргүйтгэл, халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж ажиллах,

 / М.Бадамсүрэн
/ Ч.Б.Цогтбаяр

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа-д:

4.20.Мал, амьтны гоц халдварт өвчний устгах цэгийг тэмдэглэгээжүүлэх, ариутгах, нүхийг булах, ойр орчимд айл өрх нутагшуулахгүй байх, малчдад мэдээлэх талаар сумын Онцгой комисст албан бичгээр чиглэл хүргүүлэхийг тус тус үүрэг болгов.

ДАРГА



М.БАДАМСҮРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХОШУУЧ

Б.ЦОГТБАЯР